



**Норман Хилл**  
(Бодит түүхээс сэдэвлэв)

Энэ түүх Ганад болсон.

**У**ншлагын цаг боллоо” гэж ноён Отоо хэлэв. Нямээ цэх суулаа. Уншлагын цаг үнэхээр хөгжилтэй!

Тэдний багш өдөр бүр хичээл дээрээ ангийнхандаа чангаар ном уншиж өгдөг. Заримдаа амьтдын талаар уншина. Заримдаа өөр улс орны хүмүүсийн тухай уншина. Харин заримдаа тэр ангийнхнаасаа уншуулахыг хүссэн ном байгаа эсэхийг асуудаг.

“Хэн нэгэнд өнөөдөр надаар уншуулахыг хүсэж байгаа ном байна уу?” хэмээн ноён Отоо асуув.

Нямээ гараа өргөн “Надад байна” гэлээ. Тэгээд тэр цүнхээ аван хамгийн дуртай номоо гаргаж ирэв. Энэ бол Мормоны Номын түүхүүд ном байлаа! Тэр хичээлээ тараад ээжийгээ хүлээх зуураа уншихаар үүнийг авчирсан байв. Зургууд нь судрын түүхийг ойлгоход түүнд тусалдаг байлаа.

ОЛЧ НЭЭ ДИЙЛГЭЛЭМИЙН ҮНДЭ

Ноён Отоо өнөөх том номыг хараад инээмсэглэн, “Бид бүгдийг нь уншиж амжихгүй байх. Чамд надаас уншаасай гэж хүссэн хэсэг байна уу?” гэв.

“Тийм ээ” гэж Нямээ хэллээ. Тэр хуудаснуудыг эргүүлэн, дуртай түүхээ олов. “Та энийг уншаад өгөөч? Энэ ‘Лихайн зүүд’ гэдэг нэртэй.”

“Энэ түүх юуны тухай өгүүлдэг вэ?” гэж ноён Отоо асуув.

“Энд нэгэн үзэгдэл үзсэн бошиглогчийн түүх гардаг. Тэр амтат жимстэй үзэсгэлэнт модыг харсан” хэмээн Нямээ модны зураг руу заалаа. “Тэр өөрийн гэр бүлийнхнийг түүнтэй цуг жимснээс идээсэй гэж хүссэн. Та үүнийг уншиж өгөх үү?” гээд Нямээ номоо багшдаа өгөв.

“Тэгэлгүй яах вэ” гэж Ноён Отоо хэлэв. Тэгээд тэр чангаар уншиж эхлэв. Тэр мод руу хөтлөх нарийн замын тухай уншлаа. Тэр төмөр бариулын талаар уншлаа. Мөн тэр зарлигуудыг сахих тухай уншив.

Нямээгийн найз Сэллом гараа өргөөд, “Ямар төрлийн мод байсан бэ?” гэж Нямээгээс асуулаа.

“Мэдэхгүй ээ. Гэхдээ жимс нь их гоё амттай байсан. Мангоны модноос илүү гоё мод байсан байх аа” гэж Нямээ хариулав. Тэгээд Нямээ “Би тэр жимс Бурханы хайрыг төлөөлдөг гэдгийг сүм дээр сурч мэдсэн. Амттай мөн онцгой байсан нь ийм учиртай байх нь!” гэж бодлоо.

Хичээл тарсны дараа Нямээ гадаа суугаад ээжийгээ хүлээв. Тэр Мормоны Номын түүхүүд номоо гаргаж ирээд уншлаа.

“Үнэхээр догь түүх байсан шүү” гэж Сэллом хэлээд Нямээгийн дэргэд суув. “Би чамтай хамт дахиад өөр түүх уншиж болох уу?” гэж тэр асуулаа.

“Тийм ээ!” гээд Нямээ өөр нэг түүх нээв. Тэд Абинадай, Ноа хаан хоёрын тухай уншлаа.

Ангийнх нь өөр хүүхдүүд мөн сонсохоор иржээ. Тэд асуулт асуухад Нямээ тэдэнд хариулж байлаа. Үүнээс гадна тэр уншсан түүхүүдээ ойлгосон эсэхийг шалгахад тэднээс асуулт асууж байв.

Удалгүй Нямээ ээжийгээ ирж явааг харлаа. “Надтай хамт уншсанд баярлалаа” гээд тэр номоо хаагаад инээмсэглэв. Түүний дуртай түүхүүдэд найзууд нь ч мөн дуртай байсанд тэр баяртай байлаа. ●

“Хэн нэгэнд өнөөдөр надаар уншуулахыг хүсэж байгаа ном байна уу?” хэмээн ноён Отоо асуув.

